

МОНГОЛ ХЭЛНИЙ ХИЧЭЭЛИЙН ШАЛГАЛТЫН СЭДВИЙН ХҮРЭЭНД ӨГӨХ ЗӨВЛӨМЖ

МОНГОЛ ХЭЛ, УРАНЗОХИОЛЫН БОЛОВСРОЛ, НОМЫН САН ХАРИУЦСАН МЭРГЭЖИЛТЭН Р.ӨЛЗИЙХҮҮ

1. Монгол хэлний хичээлийн “Амжилтын гараа – 4” уралдааны шалгалтыг эх, хэл зүй, найруулга, үндэсний бичиг, уран зохиол гэсэн агуулгын хүрээнд 4 хувилбар, 40 асуулттайгаар боловсруулсан.

Нийслэлийн хэмжээнд 3144 сурагч шалгагдсан байна. Сурагчдын шалгалтын авсан оноог хүснэгтээр харуулбал:


МХБУЗ	90-100	80-89	70-79	60-69	0-59
Нийт тоо	2	34	144	431	2533

Энэ хүснэгтээс харахад сурагчид монгол хэл, бичгийн хичээлийн шалгалтаас авбал зохих 40 онооноос хамгийн өндөр 36 оноог 2 сурагч авсан бөгөөд хэмжээст оноо нь 85.7 байна. Дүүргээр нь жагсаавал:

Дүүрэг	ХУД	СХД	ЧД	БНД	НД	БХД	БЗД	БГД	СБД
Гүйцэтгэлийн хувь	45,1	50,8	48,2	44,1	41,8	42,6	49	48,5	46,5

Монгол хэл, бичгийн шалгалтыг нийслэлийн хэмжээнд 46,3 хувьтайгаар шалгуулсан байна.

Сэдвийн бүтцийг шинжлэн үзвэл сонгох даалгавар 36 байгаагаас монгол хэл 25, үндэсний бичиг 6, уран зохиолын 5, сонсох даалгавар буюу уншаад ойлгох 4 даалгавартайгаар боловсруулагдсан. Агуулга тус бүрийн эзлэх хувийг графикаар харуулбал:



Сурагчдын хийсэн даалгаврын гүйцэтгэлийг “А” хувилбараар жишээ авч тайлбарлая.

“А” хувилбар

Даалгавар	1	2	3	4	5	6	7	8	9	10
Зөв хийсэн сурагчдын тоо	643	413	384	187	335	768	158	679	299	255
Нийт шалгуулагч	815	817	815	811	817	817	817	818	812	814
Гүйцэтгэлийн хувь	79	50.5	47.1	23.0	41.0	94.0	19.3	83.0	36.8	31.3
Даалгавар	11	12	13	14	15	16	17	18	19	20
Зөв хийсэн сурагчдын тоо	233	402	294	244	581	743	251	87	201	102
Нийт шалгуулагч	814	814	817	815	818	817	817	817	813	815
Гүйцэтгэлийн хувь	28.6	49.3	36.0	30.0	71.0	90.9	30.7	10.6	24.7	12.5
Даалгавар	21	22	23	24	25	26	27	28	29	30
Зөв хийсэн сурагчдын тоо	174	337	633	340	280	603	158	224	677	523
Нийт шалгуулагч	817	816	818	817	815	816	815	815	815	816
Гүйцэтгэлийн хувь	21.2	41.2	77.3	41.6	34.3	73.8	19.3	27.4	83.0	64.0
Даалгавар	31	32	33	34	35	36	37	38	39	40
Зөв хийсэн сурагчдын тоо	354	288	84	95	128	195	739	744	647	581
Нийт шалгуулагч	816	814	816	815	816	809	814	813	811	809
Гүйцэтгэлийн хувь	43.3	35.3	10.2	11.6	15.6	24.1	90.7	91.5	79.7	71.8

Сурагчдын даалгаврын гүйцэтгэлийн хувиас харахад тухайн эхийг уншаад ойлгох чадвар болон харгалзуулах даалгавруудын гүйцэтгэл сайн байна.

Сурагчид 1, 6, 8, 15, 16, 23, 26, 29, 30, 37, 38, 39, 40 дүгээр даалгавруудыг маш сайн гүйцэтгэсэн бол 2, 3, 5, 12, 17, 22, 24, 31, 32 дугаар даалгавруудыг дундаж 4, 7, 9, 10, 11, 13, 14, 18, 19, 20, 21, 25, 27, 28, 33, 34, 35, 36 дугаар даалгавруудыг маш муу гүйцэтгэсэн байна.

Иймээс багш нарт дараах зөвлөмжийг хүргүүлж байна.

1. Монгол хэл

- ✓ “Эх” сэдвийн хүрээнд эхийн гол санааг илэрхийлэх тулгуур үг, өгүүлбэрийг олуулах дасгал ажлуудыг сурагчдаар сайн хийлгүүлэх
- ✓ “Эхийн хэв маяг”, түүнийг тодорхойлох дасгал, дадлагын ажлыг сурагчдаар түлхүү хийлгүүлэх
- ✓ Өгүүлбэрийн бүтцийг дахин заан таниулах, учир зүй логик холбоог олж тогтоох, задлан шинжлэх дасгал даалгаврыг хийлгүүлэхэд анхаарах
- ✓ Өгүүлбэрийн утга бүтэц, хэрэглээг салгаж болохгүй цогц байдлаар заан эзэмшүүлэхэд анхаарах
- ✓ Үгийн утга, бүтэцтэй холбоотой дасгал ажлыг сайн хийлгүүлэх. Ялангуяа үгийн бүтэц нь зөв бичихийн, өгүүлбэр бүтэхийн эх үндэс болдог тул орхигдуулж болохгүйг анхаарах хэрэгтэй.
- ✓ Үгэнд нөхцөлийг зөв залгах, хаалт хашилтыг зөв хэрэглэх талаар “Монгол хэлний зөв бичих дүрмийн журамласан толь” УБ.,2017 номоо ашиглан, сурагчид өөрийн зохион найруулж бичсэн эхийн үг бүрийг алдаагүй зөв бичиж сурах аргад сургах, зөв бичих

дадлыг суулгах хэрэгтэйг ойлгон багш нар зөв бичих дүрмийг сурагчдадаа сайн зааж өгч байгаа нь талархуштай байна.

- ✓ Монгол хэлний боловсролыг эх дээр суурилан заах арга технологи амжилттай хэрэгжиж байгаа хэдий ч хэлнийхээ дотоод дүрэм журам, зүй тогтлыг хэт орхигдуулж байна уу даа гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Тиймээс эхэд суурилан хэл зүйгээ зохистой харьцаагаар зааж байх нь чухал санагдана. Өөрөөр хэлбэл хэл зүй, хэрэглээ хоёрыг хамтад нь авч явахын чухлыг багш нартаа сануулж байна.

2. Уран зохиол

- ✓ Уран зохиолын төрөл зүйл, орчин үеийн уран зохиол, эртний уран зохиол, монгол ардын аман зохиол талаар нэлээд нухацтай заах
- ✓ Сурагчдыг уран зохиолд дуртай, зохиолчдын уран бүтээлүүдийг харьцуулан уншдаг, шинжилгээ хийдэг, туурвил зүйн онцлогт нь дүгнэлт гаргадаг, зохиолчийн үзэл бодлыг өөрийн үзэл бодолтой харьцуулан, судлаач байдлаар идэвхтэй уншлага хийдэг болгоход бидний зорилго оршиж байгаа билээ. Иймд энэ талын асуулт даалгаврыг гүйцэтгүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.

3. Үндэсний бичиг

- ✓ Дуудлага ижил бичлэг өөр үгсийг нүдлүүлэх, зөв галиглуулахад онцгойлон анхаарах
- ✓ Үндэсний бичгийн зөв бичих дүрэмд тулгуурласан дасгал ажлуудыг сайн хийлгүүлэх
- ✓ Үндэсний бичгээр бичсэн эхүүдийг шударга, зөв уншуулах дасгал ажлуудыг сайн хийлгүүлэх
- ✓ Үндэсний бичгийн орчныг бүрдүүлэхэд анхааран ажиллах
- ✓ Үндэсний бичгээс крилл рүү хөрвүүлэх, криллээс үндэсний бичиг рүү хөрвүүлэх дасгал ажлыг сайн хийлгүүлэх

Ерөнхий дүгнэлт:

1. Сурагчдаар эх зохиолуудыг уншуулах, харилцан ярилцах, сурагчдын бүтээлч сэтгэхүйг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэн ажиллах
2. Монгол хэлний хичээлээр сурагчдын эзэмшсэн хэлний зүйн мэдлэг чадвар, уншиж ойлгох, бичиж найруулах, ярих-сонсох чадварыг хөгжүүлэхэд эх хэлний сургалтыг чиглүүлэх, чадвар дадал болгоход анхаарах
3. Шинэчилсэн цөм хөтөлбөрт дүрслэх ур маягийг таньж, тодорхойлохоос илүү тайлбарлах чадварыг хөгжүүлэхийг зорьж байгаа билээ. Тиймээс сурагчдын утга зохиолын онолын мэдлэгийг хэрэглээ болгоход анхаарах
4. Сурагчдадаа өгч байгаа гэрийн даалгавар болон сурагчдаас авч буй шалгалтын материалыг багш өөрөө хийж гүйцэтгэн үнэлж, дүгнэн ажиллах шаардлагатай байгааг анхаарч ажиллахыг зөвлөж байна.